

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2025 оны 11 сарын 25 өдөр

Дугаар A/45.

Арвайхээр сум

Тогохиолдлын удирдлагын баг томилох тухай

Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 28 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2025 оны “Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх нэгдсэн төлөвлөгөө”-ний 8 дугаар хавсралтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх Тогохиолдлын удирдлагын багийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, чиг үүргийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Тогохиолдлын удирдлагын багийг мэргэжил арга зүйгээр хангаж, шаардлагатай хариу арга хэмжээ шуурхай авч ажиллахыг Төлөвлөлт, хариу арга хэмжээний багийн дэд дарга, Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс (М.Золзаяа), Эмнэлгийн тусламжийн хэлтэс (Ю.Ичинноров) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалыг хэрэгжүүлж, хамтран ажиллахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Зоонозын өвчин судлалын төвийн захирал, дарга нарт даалгасугай.

4.Тогохиолдлын удирдлагын баг ажиллуулахтай холбоотой зардлыг шийдвэрлэж, хариу арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг тухай бүр шийдвэрлүүлэхийг нягтлан бодогч (Б.Валя)-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс (Я.Жаргал) -д тус тус даалгасугай.

ДАРГА



Н.ОЮУНТУЯА



Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн
А/45 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ТӨЛӨВЛӨЛТ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ
БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Д/д	Багийн бүрэлдэхүүн	Ажлын газар, албан тушаал
1	Багийн дэд дарга	Эрүүл мэндийн газрын НЭМХ-ийн дарга
2	Багийн дэд дарга	Эрүүл мэндийн газрын ЭТХ-ийн дарга
3	Гишүүн	Эрүүл мэндийн газрын УТХ-ийн дарга
4	Гишүүн	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн эмнэлзүй эрхэлсэн дэд захирал
5	Гишүүн	Зоонозын өвчин судлалын төвийн дарга
6	Гишүүн	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны дарга
7	Гишүүн	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн халдвараас сэргийлэх хяналтын албаны дарга
8	Гишүүн	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн поликлиникин эрхлэгч
9	Гишүүн	Эрүүл мэндийн газрын хүүхдийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
10	Гишүүн	Эрүүл мэндийн газрын халдварт өвчин, хариуцсан мэргэжилтэн
11	Гишүүн	Эрүүл мэндийн газрын эрүүл мэндийн статистик мэдээ, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн

ЭРСДЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦАА, ХОЛБООНЫ БАГИЙН
БҮРЭЛДЭХҮҮН

Д/д	Багийн бүрэлдэхүүн	Ажлын газар, албан тушаал
1	Багийн дэд дарга	Эрүүл мэндийн газрын гамшгийн үеийн тусламж үйлчилгээ, хариуцсан мэргэжилтэн
2	Гишүүн	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн гүйцэтгэлийн удирдлага, дотоод хяналтын албаны дарга
3	Гишүүн	Эрүүл мэндийн газрын боловсрол, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн

4	Гишүүн	Эрүүл мэндийн газрын олон нийт хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн
5	Гишүүн	Эрүүл мэндийн газрын мэдээллийн технологи, телемедицин хариуцсан мэргэжилтэн

САНХҮҮ, НӨӨЦИЙН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Д/д	Багийн бүрэлдэхүүн	Ажлын газар, албан тушаал
1	Багийн дэд дарга	Эрүүл мэндийн газрын ахлах нягтлан бодогч
2	Гишүүн	Эрүүл мэндийн газрын эдийн засагч
3	Гишүүн	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн ерөнхий нягтлан
4	Гишүүн	Эрүүл мэндийн газрын тоног төхөөрөмж хариуцсан мэргэжилтэн
5	Гишүүн	Эрүүл мэндийн газрын эмийн чанар аюулгүй байдал, зохистой хэрэглээ хариуцсан мэргэжилтэн
6	Гишүүн	Эрүүл мэндийн газрын хүний нөөцийн төлөвлөлт, хангалт, мэргэжлийн зөвшөөрөл, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 11 дүгээр сарын 25-ны
өдрийн 4/45 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

ТОХИОЛДЛЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ ЧИГ ҮҮРЭГ

Нэг. Тохiolдлын удирдлагын багийн үндсэн чиг үүрэг

1.1.Тохiolдлын удирдлагын баг нь томуу, томуу төст өвчин (ТТӨ)-ий дэгдэлтээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ажиллана.

1.2.Багийн үйл ажиллагаа нь ТТӨ, Амьсгалын замын цочмог хүнд халдвар (АЗЦХХ)-ын тархалтын түвшингээс хамаарч “Ажиглах үе”, “Анхааруулах үе”, “Хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх үе”, “Хариу арга хэмжээг бууруулах үе”, “Тохiolдлын удирдлагын багийг цуцлах үе” гэсэн 5 үед хуваагдана.

1.3.ТТӨ, АЗЦХХ-ын тархалтын түвшинг Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/373 дугаар тархварзүй, вирус судлалын тандалтыг томуугийн харуулдан тандалтын тогтолцоогоор тандаж, тархалтын түвшинг “Улирлын томуу, томуугийн цар тахлын хүндрэлийн үнэлгээ (УТТЦХҮ)”-ний дагуу долоо хоног бүр тогтоож, үр дүн, зөвлөмж, хариу арга хэмжээний саналыг холбогдох байгууллагуудад хүргүүлнэ.

Хоёр. Хариу арга хэмжээг зохион байгуулах үе шат

2.1.Ажиглах үе

2.1.1.Ажиглах үе гэдэг нь ТТӨ, АЗЦХХ-ын тархалтын түвшин УТТЦХҮ-гээр “Улирал хоорондын үе”-д байхыг хэлнэ.

2.1.2.Тохiolдлын удирдлагын багуудын бүтэц, бүрэлдэхүүнийг тодорхойлж, бие бүрэлдэхүүнийг сургаж бэлтгэсэн байна.

2.1.3.Холбогдох тушаал, журам, зааврын дагуу эрүүл мэндийн байгууллагуудын бэлэн байдлыг хангасан байна.

2.1.4.Салбарын болон салбар хоорондын хамтарсан хариу арга хэмжээний төлөвлөгөөг гаргаж, удирдлага зохион байгуулалтаар хангасан байна.

2.1.5.ТТӨ-ний дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан байна.

2.1.6.Эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн урвалж оношлуур, хэрэгслийг худалдан авах, нөөцийн тасралтгүй байдлыг хангах, аж ахуй нэгж, сорьц тээвэрлэх байгууллага зэрэг холбогдох байгууллагуудтай гэрээ, хэлэлцээрийг хийсэн байна.

2.1.7.Улирлын томуугийн вакцинаар эрсдэлт бүлгийн хүн амыг дархлаажуулсан байна.

2.2.Анхааруулах үе

2.2.1.ТТӨ, АЗЦХХ-ын тархалтын түвшин УТТЦХҮ-ээр “Идэвхжилийн түвшин”-д шилжсэн үеийг хэлнэ.

2.2.2.ТТӨ, АЗЦХХ-ын тархалтын түвшин нь УТТЦХҮ-ээр “Идэвхжилийн түвшин”-д шилжсэн тохиолдолд төлөвлөлт, хариу арга хэмжээний багийн дэд дарга нар ТТӨ, АЗЦХХ нь УТТЦХҮ-ээр идэвхжилийн түвшинд шилжсэн болохыг байгууллагын удирдлага, гишүүдэд мэдээлж, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлж, бэлэн байдлыг хангана.

2.2.3.Эрүүл мэндийн байгууллагуудын ТТӨ, АЗЦХХ-ын тархварзүй, эмнэлзүй, вирус судлалын тандалтыг эрчимжүүлнэ.

2.2.4.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг болон хүн ам ихээр цуглардаг газар, хаалттай орчин бүхий байгууллагуудад голомтолсон өвчлөл, үйл явдлын тандалтыг нэмэгдүүлнэ.

2.2.5.Хүн амд ТТӨ-өөс урьдчилан сэргийлэх талаар сургалт, сурталчилгааг эрчимжүүлэн цахим тандалтыг хийж, холбогдох газруудад мэдээлнэ.

2.2.6.Эрүүл мэндийн байгууллагууд, ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад дэмжлэгт хяналт хийж, бэлэн байдлыг хангуулна.

2.3.Хариу арга хэмжээний үе

2.3.1.Хариу арга хэмжээний үе гэдэг нь ТТӨ, АЗЦХХ-ын тархалтын түвшин УТТЦХҮ-ээр “Алаг цоог, аймгийн хэмжээний дэгдэлт, тахалт тархалтын түвшин”-д шилжсэн үеийг хэлнэ.

2.3.2.Төлөвлөлт, хариу арга хэмжээний багийн дэд дарга нар багуудыг хариу арга хэмжээний цар хүрээ, гүйцэтгэх үйл ажиллагаанаас хамаарч идэвхжүүлнэ.

2.3.3.Хариу арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг зохион байгуулна.

2.3.4.Тохиолдлын удирдлагын багийн гүйцэтгэж буй үйл ажиллагааны талаар Эрүүл мэндийн газрын дарга, холбогдох удирдлагуудад танилцуулна.

2.3.5.ТТӨ, АЗЦХХ-ын тархалтын түвшинтэй уялдуулж ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, үйлчилгээний газар зэрэг хүн ам олноор цуглардаг газруудын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох, цагийн хуваарьт өөрчлөлт оруулах саналыг холбогдох байгууллага, удирдлага, албан тушаалтанд хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

2.3.6.Шаардлагатай үед нэмэлтээр ор дэлгэх, эмнэлгийн тусламж үйлчилгээний зохион байгуулалтыг хийнэ.

2.4.Хариу арга хэмжээг бууруулах үе

2.4.1.ТТӨ, АЗЦХХ-ын тархалтын түвшин нь УТТЦХҮ-ээр “Алаг цоог дэгдэлтийн түвшин”-ээс буурч “Идэвхжилийн түвшин”-д шилжсэн үеийг хэлнэ.

2.4.2.Хариу арга хэмжээний цар хүрээг багасгаж, хэрэгжүүлэх үйл ажиллагаанаас хамаарч зарим багуудыг цуцална.

2.4.3.ТТӨ, АЗЦХХ-ын тархалтын түвшин нь “Идэвхжилийн түвшин”-д шилжсэн тохиолдолд Тохиолдлын удирдлагын багийн үйл ажиллагааг ажиглалтын үе рүү шилжүүлнэ.

2.4.4.Нэмэлтээр дайчлан ажиллуулж байсан хүний нөөц, уртасгасан цагийг цуцлана.

2.5.Тохиолдлын удирдлагын багийн үйл ажиллагааг зогсоож, тайван цагийн горимд шилжүүлэх

2.5.1.ТТӨ, АЗЦХХ-ын тархалтын түвшин УТТЦХҮ-ээр “Идэвхжилийн түвшин”-гээс буурч “Улирал хоорондын түвшин”-д шилжсэн үеийг хэлнэ.

2.5.2.Тохиолдлын удирдлагын багийн үйл ажиллагааг цуцалж, авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээний тайлан, үнэлгээ болон цаашид өөрчлөх асуудлыг хэлэлцэн, Эрүүл мэндийн газар болон холбогдох удирдлагуудад санал хүргүүлнэ.

2.5.3.Тохиолдлын удирдлагын багийн саналыг үндэслэн тайван цагийн горимд шилжүүлэх шийдвэрийг холбогдох удирдлагууд гаргана.

Гурав. Тохиолдлын удирдлагын багуудын чиг үүрэг

Мэргэжлийн баг	Чиг үүрэг
Төлөвлөлт, хариу арга хэмжээний багийн дэд дарга	ТТӨ, АЗЦХХ-ын тархалтын түвшингээс хамаарч мэргэжлийн багуудыг үүрэгжүүлж, идэвхжүүлнэ. ТТӨ-ий дэгдэлтийн бэлэн байдал, хариу арга хэмжээг нэгдсэн удирдлагаар хангаж, зохион байгуулна. Тохиолдлын удирдлагын тогтолцоогоор ажиллаж, мэргэжлийн багийг идэвхжүүлэх, цуцлах, эсвэл бие бүрэлдэхүүнийг өргөжүүлэх, багасгах зэрэг шийдвэрүүдийг өвчлөлийн байдалтай уялдуулан гаргаж, хэрэгжүүлнэ. ТТӨ, АЗЦХХ-ын тархалтын түвшингээс хамаарч төлөвлөлт, хариу арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг мэргэжлийн багуудтай хамтран удирдан боловсруулж, хэрэгжүүлнэ. Дээд шатны шийдвэр гаргагч, хамтран ажиллагч байгууллагуудын удирдлагуудыг дэгдэлтийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээллээр хангана. Багийн дэд дарга нар үйл ажиллагаатай холбоотой шуурхай хурлыг удирдан, зохион байгуулж, хариу арга хэмжээтэй холбоотой гарсан шийдвэр, үйл ажиллагааг тухай бүрд танилцуулан багуудын уялдаа холбоог хангаж ажиллана. Өвчлөлийн нөхцөл байдал, хариу арга хэмжээний явц, үр дүнгийн талаарх албан ёсны мэдээллийг олон нийтэд хандан хийнэ. Мэргэжлийн байгууллагуудад өгөх мэдээлэл, иргэдэд

	зориулсан сургалт, сурталчилгааны материал зэргийг баталгаажуулна. Хариу арга хэмжээний нэгдсэн тайланг хянан, баталгаажуулна.
Төлөвлөлт, хариу арга хэмжээний багийн бүрэлдэхүүн	ТТӨ-ний эрсдэлийн үнэлгээ хийж, үнэлгээнд үндэслэн хариу арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ. ТТӨ, АЗЦХХ-ын дэгдэлтийн үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээ, дэгдэлтийн өмнө ба дараах үед авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. Санхүү, нөөцийн багтай хамтран нөөц (эм, урвалж, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодис, тоног, төхөөрөмж, техник хэрэгсэл, хамгаалах хувцас хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодис, хүний нөөц гэх мэт)-ийн төлөвлөлтийг хийнэ. ТТӨ, АЗЦХХ-ын өвчлөлийн мэдээ, авч хэрэгжүүлж буй хариу арга хэмжээ, нөөц, санхүүжилт зэрэг холбогдох мэдээллийг мэргэжлийн багуудаас авч нэгтгэн, хариу арга хэмжээний нэгдсэн тайлан бэлтгэнэ. Хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай, заавар, журам, түр заавар, албан даалгавар зэрэг бодлогын баримт бичгийг боловсруулж тайлан, мэдээг бүртгэж архивлана. Санхүү, нөөцийн багаас нөөцийн бүрдүүлэлт, зарцуулалтын мэдээг авч архивлана. Улирлын томуугийн эсрэг дархлаажуулалтыг зохион байгуулна. Өвчтөний эмнэлзүйн менежментийн чиглэлээр заавар, зөвлөмж боловсруулан, эрүүл мэндийн байгууллагуудад мэргэжил аргазүйн зөвлөмж, дэмжлэг үзүүлнэ. Тархварзүй, вирус судлал, эмнэлзүйн тандалт судалгаа хийж, багууд, холбогдох удирдлагуудыг мэдээллээр хангана. ТТӨ-ий дэгдэлтийн голомтод хариу арга хэмжээ шуурхай зохион байгуулж, хүн амын дунд халдварын тархалтыг бууруулах, эрсдэлт бүлгийн хүн амыг хүндрэх, нас барахаас сэргийлэх, халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.
Эрсдэлийн мэдээлэл харилцааны баг	Эрсдэлийн мэдээлэл харилцааны багийн дэд дарга нь үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж, хэрэгжилтийг ханган ажиллана. ТТӨ, АЗЦХХ-ын тархалтын түвшин “Идэвхжилийн үе”-д шилжсэн хугацаанаас эхлээд “Улирал хоорондын түвшин”-д хүртэл ТТӨ-тэй холбоотой бүхий л сэдвээр иргэд, хамтран ажиллагч байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд хэвлэлийн мэдээ, зурагт хуудас, богино хэмжээний кино гэх

	мэт тохиромжтой бүх хэлбэрээр бэлтгэн түгээнэ. ТТӨ, АЗЦХХ-ын тархалтын түвшин “Улирал хоорондын үе”-д байхад олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллага, цахим хуудас, телевиз, радио болон хэвлэлийн байгууллагуудтай гэрээ хийж, мэдээлэл түгээх сувгийг тодорхой болгож, бэлэн байдлыг хангасан байна. Шаардлагатай тохиолдолд хэвлэлийн бага хурлыг зохион байгуулах ба хэвлэл мэдээллийн байгууллагын бүртгэлийг гаргаж, дуудан цуглуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна. Төлөвлөлт, хариу арга хэмжээний багийн иргэдэд мэдээлэл хийхэд зориулсан хэвлэлийн бага хурлын мэдээллийг бэлтгэж, танилцуулна. Хэвлэл мэдээллийн байгууллага болон бусад байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэнэ. Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр цацагдаж буй ТТӨ-тэй холбоотой мэдээллийг тандан судалж, худал, ташаа мэдээллийг залруулах, иргэдийн мэдээллийн хэрэгцээнд тохирсон мэдээллийг бэлтгэн түгээх ажлыг зохион байгуулна. Иргэдийн онцлогт тохирсон мэдээлэл хүргэх чиглэлээр төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэн ажиллана. Улирлын томуугийн эсрэг дархлаажуулалтын талаар мэдээлэл бэлтгэж, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх чиглэлээр ажлыг зохион байгуулна.
Санхүү, нөөц зохицуулалтын баг	ТТӨ, АЗЦХХ-ын дэгдэлтийн үед авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээнд шаардлагатай нөөцийн судалгаа гаргаж, нөөцийг бүрдүүлэх, хуваарилах, зарцуулалтад хяналт тавих Бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын ТТӨ-ий дэгдэлтийн үед хэрэглэгдэх нөөцийн судалгааг гаргуулан, нөөц бүрдүүлэх арга хэмжээг авна. Шаардлагатай үед ажиллах хүний нөөцийн судалгааг гаргаж, бэлэн байдлыг хангана. Хариу арга хэмжээний багаас ирүүлсэн нөөцийн зарцуулалтын хүсэлтийг хүлээн авч, шуурхай ханган, нийлүүлнэ. Шаардлагатай эм, урвалж, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, хүчилтөрөгч, вакцины бэлэн байгаа нөөцийн судалгааг төрөл, зүйлээр долоо хоног тутамд шинэчлэн гаргаж танилцуулна. Шаардлагатай тохиолдолд вакцин болон бусад шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийг дотоодын эсвэл олон улсын нийлүүлэгч, байгууллагаас яаралтай худалдан авах, байршуулах, түгээх ажлыг зохицуулна.

	Багуудын болон хариу арга хэмжээнд дайчлагдан ажиллаж буй бие бүрэлдэхүүний ажилласан нэмэлт цагийн тооцоог бүртгэх, цалинг тооцож олгох
--	--

---oOo---